



[/ГТЕГ-ын 2016-02-24-ний А/40 тушаалаар хүчингүй болсон/](#)

Улсын гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 676 дугаар тушаалын

1 дүгээр хавсралт

БАРААГ ДОТООДЫН ХЭРЭГЛЭЭНД ЗОРИУЛАН ОРУУЛАХ ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах гаалийн бүрдүүлэлтийн горим /Гаалийн тухай хуулийн 82-84 дугаар зүйл, цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн тухай хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.
- 1.2. Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горим сонгох, бичиг баримт бүрдүүлэх, татвар, хураамж ногдуулах, төлөх, хураан авах, барааг горимд байршуулах, горим дуусгавар болгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.3. Горимыг мэдүүлэгч сонгох бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1. Горимд гаалийн тухай хуулийн 83 дугаар зүйлд заасан барааг байршуулна.

2.2. Энэ журмын 2.1-д заасан бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарна.

2.3. Горимд дараахь кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах	400	шаардахгүй
2	Олон улсын гэрээний дагуу гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	401	шаардахгүй
3	Гадаад орны засгийн газар, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээний дагуу гаалийн болон бусад татвараас чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	402	шаардахгүй
4	Монгол улсын хуулийн дагуу гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	403	Хилийн чанадаас оруулах бараанд шаардахгүй Бусад горимоос оруулах бараанд шаардана
5	Гаалийн болон бусад татвараас чөлөөлж оруулсан барааг гаалийн болон бусад татварыг төлүүлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	410	401-403
6	Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах автобензин, дизелийн түлш		
	Цагааннуур, Боршоо, Ярант, Тэс, Бургастай, Арцсуурь, Гашуун сухайт, Бичигт, Хавирга, Шивээхүрэн	411	шаардахгүй
	Ханх, Ульханмайхан	412	шаардахгүй
	Эрээнцав, Замын Үүд, Сүхбаатар, Алтанбулаг	413	шаардахгүй
	Баянхошуу	414	шаардахгүй
7	Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах	420	500, 508, 509, 510, 511, 512, 515



8	Олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах	421	507, 514, 517
9	Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулахаар оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах:		
	-тухайн барааг боловсруулсан, эсхүл баяжуулсан	431	561,571,581,591
	-тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн	432	562, 572, 582, 592
10	Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулахаар оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах:		
	-тухайн барааг боловсруулсан, эсхүл баяжуулсан	441	501,521, 531, 541, 551
	-тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн	442	502, 522, 532, 542, 552
	-тухайн бараанд засвар хийсэн	443	503, 523, 533, 544, 554
	-тухайн барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигласан	444	504, 524, 534, 544, 554
11	Гаалийн баталгаат бүсээс дотоодын хэрэглээнд зориулан оруулах:		
	-гаалийн баталгаат агуулахаас	451	700, 703-708
	-гаалийн баталгаат үйлдвэрийн газраас	452	710, 713-716
	-гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас	453	720, 723-725
	-гаалийн баталгаат барилгын талбайгаас	454	730-734
	-гаалийн тусгай бүсээс	455	750-753, 758-765
	-татваргүй барааны дэлгүүрээс	456	740,742-743
12	Чөлөөт бүсээс дотоодын хэрэглээнд зориулан оруулах	460	770-773,778-787
13	Бүрдүүлэлтийн дараахь шалгалтын үр дүнгээр	470	шалгалтын акт
14	Гаалийн бусад хяналтаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах	480	шаардахгүй
15	Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах валют, үнэт цаас	404	Шаардахгүй
16	Хилийн чанадад түр хугацаагаар гаргасан барааг буцаан оруулахад	481	331
17	Хилийн чанадад боловсруулахаар гаргасан барааг буцаан оруулахад:		
	— барааг боловсруулах, эсхүл баяжуулах	482	332
	— тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж		
	— засвар хийх	483	333
	— барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах		



		484	334
		485	335
18	Гаалийн баталгаат бүсээс дотоодын хэрэглээнд зориулан оруулах:		
	Цагааннуур, Боршоо, Ярант, Тэс, Бургастай, Арцсуурь, Гашуун сухайт	457	700
	Ханх ,Ульханмайхан	458	700
	Эрээнцав, Замын Үүд, Сүхбаатар, Алтанбулаг	459	700
19	Гаалийн баталгаат бүсээс гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах		
	Олон улсын гэрээний дагуу гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	461	700 720 750 730
	Гадаад орны засгийн газар, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээний дагуу гаалийн болон бусад татвараас чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	462	700 720 750
	Монгол Улсын хуулийн дагуу гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	463	700 720 750
20	Гаалийн баталгаат бүсээс гаалийн болон бусад татвараас чөлөөлж оруулсан барааг гаалийн болон бусад татварыг төлүүлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	490	461-463
21	Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах гурил Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Бургастай	417	шаардахгүй
	Бусад боомт	418	шаардахгүй
22	Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг гаалийн болон бусад татвараас чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	422	500, 508, 509, 511, 512
	Ашигт малтмалын тухай хуульд заасан хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор	415– /хүчингүй/	шаардахгүй
	Олборлосон нүүрсээ экспортод гаргахгүйгээр дотоодын хэрэгцээнд тогтмол нийлүүлдэг Ашигт малтмалын тухай хуульд заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор	416- /хүчингүй/	шаардахгүй
Гаалийн баталгаат аг			



уулахаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах:			
	Ашигт малтмалын тухай хуульд заасан хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор	488- хүчингүй	700
	Олборлосон нүүрсээ экспортод гаргахгүйгээр дотоодын хэрэгцээнд тогтмол нийлүүлдэг Ашигт малтмалын тухай хуульд заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор	489- хүчингүй	700
	Монгол Улсын Олон улсын гэрээний дагуу Монгол-ОХУ-ын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн хэрэгцээнд зориулан гаалийн болон нэмэгдсэн өртгийн /бусад/ татвараас чөлөөлж оруулах	419- хүчингүй	Шаардахгүй
23	Чөлөөт бүсэд боловсруулахаар оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах:	464	770
	- үйлдвэрлэл явуулсан	465	771
	- боловсруулалт хийх	466	772
	- үйлчилгээ үзүүлэх	467	773
	- бусад зориулалтаар оруулах		

24.	Гаалийн баталгаат агуулахаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах гурил		Өмнөх гор
	Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Бургастай	471	70
	Бусад боомт	472	70

25	Хилийн чанадаас иргэний агаарын тээврийн салбарт ашиглах зорилгоор агаарын хөлгийн шатахууныг оруулах		Өмнөх гори
	Замын-Үүд, Сүхбаатар боомтоор	405	Шаардахгүй
	Гаалийн баталгаат агуулахаас	406	700

/18-20 дахь заалтыг 2011 оны 254-р тушаалаар, 21-22 дахь заалтыг 2012 оны 67, 2013 оны A/77, 2013 оны A/250 дугаар тушаалаар, 24 дэх заалтыг 2014 оны A/89, 25 дахь заалтыг 2014 оны A/105 дугаар тушаалаар тус тус нэмэлт оруулсан/

/2.3 дахь заалтын хүснэгтэд ГЕГ-ын даргын 2009 оны 363, 2011 оны 254, 2012 оны 67, 2012 оны 221, 2012 оны 235, 2014 оны A/131 дүгээр тушаалаар нэмэлт орсон/, /2015 оны A/209 дүгээр тушаалаар 16, 17 дахь хүснэгт, 22 дахь хүснэгтийн код 415, 416, 419, 488, 489-ийг хүчингүй болгосон/

Гурав. Бичиг баримт

- 3.1. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд дараахь бичиг баримтыг шаардана.
 - 3.1.1. ачааны манифест;
 - 3.1.2. гадаад худалдааны гэрээ, эсхүл захиалга;
 - 3.1.3. худалдааны бичиг баримт /үнийн нэхэмжлэх, баглаа боодлын жагсаалт, техникийн бичиг баримт гэх мэт/;
 - 3.1.4. тээврийн бичиг баримт;
 - 3.1.5. гарал үүслийг нотлох баримт;
 - 3.1.6. эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, лиценз, сертификат;
 - 3.1.7. гадаад төлбөр тооцооны баримт;
 - 3.1.8. гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөх бол түүнийг баталгаажуулах эрх бүхий байгууллагын баримт;
 - 3.1.9. гаалийн үнийг батлах бичиг баримт;
 - 3.1.10. барааны чанарын гэрчилгээ, тохирлын гэрчилгээ, шинжилгээний дүгнэлт /шаардлагатай бол/;
 - 3.1.11. гаалийн болон бусад албан татвар, хураамж төлсөн баримт;
 - 3.1.12. шаардлагатай бусад бичиг баримт.

3.2. Мэдүүлэгч 3.1-д заасан бичиг баримтыг электрон шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.3. Журмын 3.1-д заасан мэдээлэл, баримт бичиг нь горимын шаардлага хангахгүй байвал гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.4. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Монголын гааль зөвшөөрөв” хяналтын тэмдэг дарна.

Дөрөв. Горимын шаардлага

4.1. Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол гаалийн байгууллага барааг мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулахаас татгалзана.

4.2. Гаалийн байгууллагаас ногдуулсан гаалийн болон бусад татварыг бүрэн төлсөн, эсхүл Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.2-т заасны дагуу татвар төлөх баталгаа гаргасан тохиолдолд энэ горимын дагуу бүрдүүлэлт хийнэ.

4.3. Импортын гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдсөн барааг гаалийн байгууллагын зөвшөөрснөөс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

4.4. Энэ журмын 4.3-т заасан бараа нь гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэнд байгаад тооцогдохгүй.

4.5. Энэ горимд байршуулах барааны гаалийн болон бусад татварыг ногдуулах, төлөх, хураан авах, баталгаа гаргуулах, буцаан олгохтой холбогдсон асуудлыг Гаалийн тариф, татварын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

4.6. Гаалийн бүрдүүлэлтийн горимын 420, 431, 432, 441-444 кодоор гаалийн бүрдүүлэлт хийхэд гаалийн болон бусад татварыг ногдуулж, өмнөх гаалийн мэдүүлгийг үндэслэн гаалийн болон бусад татварыг төлүүлэхгүй, төрийн сангийн тусгай дансад байршуулсан мөнгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

Тав. Бусад

5.1. Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горим нь барааг мэдүүлэгчид олгосноор, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болно.

5.2. Горимд байршуулсан бараа нь гаалийн зөрчлийн улмаас хураагдсан бол горимын үйлчлэл дуусгавар болсонд тооцно.